

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 19

№Т/39

Улаанбаатар хот

**СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дүгээр зүйлийн 76.1.16, 76.1.17 Эм жи эл акуа ХК-ийн дүрмийн 7.21.16 дэхь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймагт байгуулах 4100 м.кв цэвэр усны үйлдвэрийн барилга, дэд бүтцийн ажлыг гүйцэтгэх зорилгоор Ньюгор ХХК-тай 7,897,649,593.1 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг Эм жи эл акуа ХК-ийн охин компани Ти эм эл акуа ХХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулах, гарын үсэг зурах эрхийг Ти эм эл акуа ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Дашзэвэг/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороо /Ч.Анхбаяр/ -нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С. АЛТАНТУЯА